

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ДОРНОГОВЬ АЗЗА ТӨХК-ийн 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын код: ДГА-2021/1/СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2021он

Аудитын дөрөвдүгээр газрын захирал,
тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас:

Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас:

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Гэрэлт хөхийн тэнцвэр
Аудит” ХХК

Утас: 99099119 Цахим хаяг: gerelt.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БХЯ	Батлан хамгаалах яам
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
САГ	Санхүүгийн тайлангийн аудит
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТТТ	Таван толгой түлш
РЛС	Радиолокацийн станц
ХШУДАГ	Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ААНБООТ	Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
3.Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал	10
3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	11
3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа	13
3.8. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.10. Аудитын илрүүлэлт.....	13
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	13
4. Менежментийн захидал	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

1.Төрийн аудитын санал, дүгнэлт**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.03.19 № 16/298
танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЗЗА ТӨХК-ИЙН
ЗАХИРАЛ А.БАТТОГТОХ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.
Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

440020578

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	53,482,973.82	131,423,275.54
1.1.2	Дансны авлага	50,354,895.00	0.00
1.1.4	Бусад авлага	37,677,590.04	37,677,590.04
1.1.6	Бараа материал	481,838,125.92	466,166,867.04
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	433,193,252.64	220,637,429.09
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,056,546,837.42	855,905,161.70
1.2.1	Үндсэн хөрөнгө	607,632,733.52	544,874,352.44
1.2.2	Биет бус хөрөнгө	180,920,500.00	180,920,500.00
1.2.9	Хуримтлагдсан элэгдэл-Биет бус хөрөнгө	(192,500.00)	(522,500.00)
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	788,360,733.52	725,272,352.44
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,844,907,570.94	1,581,177,514.15
2.1.1.1	Дансны өглөг	182,100,566.58	66,760,495.38
2.1.1.3	Татварын өр	53,931,111.51	47,798,131.80
2.1.1.4	НДШ - ийн өглөг	14,334,305.51	64,515,153.46
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	250,365,983.60	179,073,780.64
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	295,518,696.00	295,518,696.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	295,518,696.00	295,518,696.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	545,884,679.60	474,592,476.64
2.3.1	Өмч: - төрийн	1,259,316,594.42	1,256,228,397.66
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	31,497,846.00	31,497,846.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	283,470,693.51	283,470,693.51
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	104,036,772.40	104,036,772.40
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(379,299,014.97)	(568,648,672.06)
2.3.10	Тайлангийн үеийн хуримтлагдсан ашиг	0.00	(189,349,657.08)
	Өмнөх үеийн ашиг	(379,299,014.97)	(379,299,014.97)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,299,022,891.35	1,106,585,037.51
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	1,844,907,570.95	1,581,177,514.15

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тайлант он
31	Борлуулалтын орлого (цэвэр)	2,285,093,579.99
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,610,330,988.62
3	Нийт ашиг (алдагдал)	674,762,591.37
5	Хүүний орлого	112,411.21
8	Бусад орлого	17,129,600.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	680,557,047.28
11	Санхүүгийн зардал	327,989.15
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	11,119,566.16
20	Татварын дараах ашиг (алдагдал)	11,119,566.16
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	11,119,566.16
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00
	Бусад олз (гарз)	0.00
24	Орлогын нийт дүн	11,119,566.16
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2019 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	1,394,851,212.82	442,494,414.22	5,546,600.60	(489,238,219.56)	1,353,654,008.08
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
2020 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	1,394,851,212.82	442,494,414.22	5,546,600.60	(489,238,219.56)	1,353,654,008.08
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(189,349,657.08)	(189,349,657.08)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
2020 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	1,394,851,212.82	442,494,414.22	5,546,600.60	(678,587,876.64)	1,164,304,351.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан
/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,522,121,213.02
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,427,237,033.00
	Бусад мөнгөн орлого	94,884,180.02
1.2	Мөнгөн зарлага (-)	2,381,143,472.30
	Ажиллагчдад төлсөн	549,630,650.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	110,666,586.29
	Бараа материал худалдан авахад төлсөн	740,723,049.00
	Ашиглалтын зардалд төлсөн	22,412,954.49
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	784,426,708.20
	Татварын байгууллагад төлсөн	141,346,158.12
	Даатгалын төлбөрт төлсөн	4,017,720.00
	Бусад мөнгөн зарлага	27,919,646.20
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	140,977,740.72
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	13,300,000.00
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	13,300,000.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	70,000,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	70,000,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(56,700,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,687,439.00
	Төлсөн ногдол ашиг	1,687,439.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,687,439.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	82,590,301.72
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	53,482,973.82
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	131,423,275.54

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг гүйцэтгэх захирал А.Баттогтох танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, цалин хөлс, анхан шатны баримтын бүрдүүлэлт, өглөг, дансдын үлдэгдэл, санхүүгийн тайлангийн тодруулгын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн аудитор Ж.Ням-осор, Э.Буяндэлгэр нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь АЗЗА ТӨХК 2020 оны санхүүгийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 31 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорноговь АЗЗА ТӨХК нь "Зөв төлөвлөлт, чанартай бүтээн байгуулалт, үр дүнтэй хяналт" гэсэн зорилтын хүрээнд төрийн захиргааны байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг хариуцсан замын хэмжээнд зохион байгуулж түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн 4 улирлын туршид бүрэн хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Компаний үүсгэн байгуулах баримт бичигт зааснаар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Авто замын байгууламжийг барих, засварлах.

Монгол улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.15.4 заалт, "Авто замын тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтуудын дагуу олгосон 2017/047 тоот тусгай зөвшөөрөлд дараах ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс гурван жилийн хугацаатай олгосон байна. Үүнд:

- Хатуу хучилттай зам барих.
- Хайрган хучилттай зам барих
- Хатуу болон хайрган хучилттай зам барих
- Төмөр бетон, ган төмөр, модон гүүр засварлах
- Зам, замын байгууламжид хамаарах талбай барих, засварлах
- Үерийн хамгаалалтын далан барих
- Тавилан барих, засварлах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар даатгуулагч болон ажил олгогчоос төлөх шимтгэлийн өөрчлөлт;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх өөрчлөлт орсон байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дорноговь АЗЗА ТӨХК санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаагүй, өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тодорхой тусгаж харуулаагүй байна.

Тайлант онд тус байгууллагын 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2020 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөс ажлын 21 хоногт хийсэн байна.

Дотоод аудит, хяналт шалгалтаар нийт 7.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 1.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 6 зөвлөмж өгсөн байна.

Дорноговь АЗЗА ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 2,285.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 45.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,713.7 сая төгрөгөөр буюу 16.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	54.5	131.4	76.9
Авлага	88.0	37.7	-50.3
Урьдчилгаа			
Бараа материал	481.8	466.2	-15.6
Үндсэн хөрөнгө	788.4	725.3	-63.1

Нийт хөрөнгийн дүн	1,844.9	1,581.2	-263.7
Өр төлбөр	545.9	474.6	-71.3
Урьдчилж орсон орлого			
Эздийн өмч	1,299.0	1,106.6	-192.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,844.9	1,581.2	-263.7

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 131.4 сая төгрөг болж 76.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь санхүүжилт оны сүүлд орсонтой холбоотой нэмэгдсэн байна.

Авлага дансны үлдэгдэл 37.7 сая төгрөг болж 50.3 сая төгрөгөөр буурсан урд онд гүйцэтгэсэн ажлын санхүүжилт төлөгдсөнөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 481.8 сая төгрөг болж 15.6 сая төгрөгөөр буурсан нь албан хэрэгцээнд зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 725.3 сая төгрөг болж 63.1 сая төгрөгөөр буурсан нь хөрөнгө акталсан болон элэгдлийн зардлаар буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 474.6 сая төгрөг болж 71.3 сая төгрөгөөр буурсан шатахууны өглөгийг барагдуулсан нь нөлөөлсөн байна. Богино хугацаат өр төлбөрийн дансанд нийгмийн даатгалын болон татварын байгууллагад төлөх өр төлбөр байна. Урт хугацаат өр төлбөрт 2019 онд Зам, тээврийн хөгжлийн яамаас Кувейтын сангийн хөрөнгөөр ирсэн тоног төхөөрөмжийн үнэ 295.5 сая төгрөгийн өглөг байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 1,106.6 сая төгрөг болж 192.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3,20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Дорноговь АЗЗА ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалт газрын 2019 оны 583 тоот тогтоолоор Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, үр ашгийн төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,380.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,370.7 сая төгрөгөөр 9.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 2,302.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,291.2 сая төгрөгийн зардал гарган, 11.0 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь Зам тээвэр, хөгжлийн яамнаас улсын чанартай зам засвар, арчлалтын санхүүжилт 1,612.5 сая, тендерээр авч гүйцэтгэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн авто замын ажлын санхүүжилт 650.1 сая төгрөг, акталсан хөрөнгө худалдсаны орлого 13.3 сая төгрөг, бусад орлогоор 26.2 сая төгрөг, хүүний орлого 0.1 сая төгрөгөөс бүрджээ.

Хүснэгт 1. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

Д.Д	Үзүүлэлт	Хэмжээ их сая	2019 Оны төлө	2019 Оны гүйцэтгэл	2020 оны	Өмнөх оны гүйцэтгэлтэй	Төлөвлөгөөт эй
-----	----------	---------------------	---------------------	--------------------------	----------	---------------------------	-------------------

					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Зөрүү	Хувь
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт		1,152.0	1,354.2	1,380.0	2,302.2	(948.0)	70	(228.0)	20
1.1	Үйл ажиллагааны орлого	төг	751.2	757.9	880.0	1,628.7	(870.8)	115	(128.8)	17
1.2	Хүү, валютын ханшийн орлого	төг					-	-	-	-
1.3	Борлуулалтын орлого	төг					-	-	-	-
1.4	Бусад борлуулалтын орлого	төг	400.8	596.3	500.0	673.5	(77.2)	13	(99.2)	25
2	Нийт орлого		1,152.0	1,354.2	1,380.0	2,302.2	(948.0)	70	(228.0)	20
3	Үүнээс: Цэвэр борлуулалт	төг					-	-	-	-
4	Нийт зардал		1,144.7	1,341.2	1,370.7	2,291.2	(950.0)	71	(226.0)	20
	Үүнээс:						-	-	-	-
4.1	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	төг	882.6	1,088.7	1,044.8	1,771.9	(683.2)	63	(162.2)	18
4.2	б) Ерөнхий ба удирдлагын зардал	төг	193.7	184.2	255.9	449.3	(265.1)	144	(62.2)	32
4.3	в) Хөрөнгө оруулалт их засвар	төг	68.4	68.3	70.0	70.0	(1.7)	2.5	(1.6)	2.3
	Цэвэр ашиг, алдагдал		6.5	11.2		10.0	1.2	1.1	6.5	-

Нийт орлогын гүйцэтгэл 2,302.2 сая төгрөг болж төлөвлөснөөс 922.2 сая төгрөг буюу 66.8 хувиар давсан нь Зам тээврийн хөгжлийн яамнаас улсын чанартай авто зам засвар, арчлалтын санхүүжилт нэмэгдсэн болон тендерээр ажил авч гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 1,628.7 сая төгрөг болж төлөвлөснөөс 748.7 сая төгрөг буюу 85.1 хувиар давсан нь Зам тээврийн хөгжлийн яамнаас улсын чанартай авто зам засвар, арчлалтын санхүүжилт нэмэгдсэн холбоотой байна.

Бусад орлогын гүйцэтгэл 673.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 173.5 сая төгрөг буюу 34.7 хувиар давсан нь тендерээр ажил гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,291.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 920.5 сая төгрөг буюу 67.2 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь улсын чанартай авто зам засвар, арчлалтын санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотойгоор үйл ажиллагааны зардал нэмэгдэх гол нөлөө үзүүлсэн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 4, Зам тээврийн хөгжлийн яам 3, хараат бус 3, нийт 10 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2020 онд 5 удаа зохион байгуулж 7 асуудлуудыг хэлэлцэж 5 тогтоол, 1 тэмдэглэлийг шийдвэрлэсэн байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд нийт 47.1 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 46.6 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: Цалин хөлс, НДШ-ийн зардалд 46.6 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 0.5 сая төгрөгийг тус тус санхүүжүүлсэн байна

3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		/сая.төг/ Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	0.5	1	0.5	100
Зөвлөмж	7	6.9	6	6.9	85
Нийт дүн	8	7.4	7	7.4	

Айраг суманд байрлах кемпийн барилгын газар нь иргэдийн өмчилж авсан газартай давхацсан бөгөөд дахин үнэлгээ хийгдээгүй, иргэд газраа чөлөөлүүлэхээр аймаг, сумын төр захиргааны байгууллагад удаа дараа хүсэлт гаргаж байгаа зөрчилд хөрөнгөтэй холбоотой бичиг баримтыг судлах, газрын өмчлөлтэй холбоотой баримтыг холбогдох иргэн, төрийн байгууллагаас гаргуулан авч ТУЗ-д танилцуулан цаашид хөрөнгийг хэрхэн ашиглах, газрын асуудлыг шийдвэрлүүлэх зөвлөмж өгсөн дагуу ТУЗ-ийн хурлаар худалдан борлуулахаар шийдвэрлэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт санал хүргүүлсэн шийдвэрлэгдээгүй байна.

3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 16.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Цар тахалтай холбоотойгоор тухайн байгууллагад очиж хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хөрөнгийн хэсэгчилсэн тооллого хийгээгүй тул цаашид хөрөнгийн ашиглалтын хугацаа, хадгалалт, хамгаалалтын талаар дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн тавилга хэрэгслийн дансанд 6 нэр төрлийн тоног төхөөрөмж, компьютер бүртгэсэн нь Сангийн Сайдын 2017 оны 361 дүгээр дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх” зааврын “1.Үндсэн хөрөнгө”-ийн д-д “Тавилга, эд хогшил: Нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах тавилга, аж ахуйн эд хогшил, багаж хэрэгслүүд”, е-д “Компьютер, бусад хэрэгсэл: Компьютер, хэвлэх, хувилах төхөөрөмж болон бусад хэрэгслүүд” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэлгээ”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн үзүүлэлт буруу илэрхийлэгдэх.

1.3. Өгсөн зөвлөмж

Дээрх зөрчлийг залруулж, санхүүгийн тайланд үнэн зөв тусгаж ажиллах шаардлагатай байна.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бараа материалын дансанд 4.4 сая төгрөгийн хөрөнгийг нэр төрлөөр тайлан бүртгэлд тусгалгүй материал гэж нийт дүнгээр бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалттай нийцэхгүй “үнэлгээ”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:

Нэр төрлөөр бус нийт дүнгээр зарлагдах.

2.3. Өгсөн зөвлөмж

Бараа материалыг нэр төрөл тус бүрээр тайлан бүртгэлд тусгаж байх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн.

3. Балансын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Бараа материалын данс бүртгэлд 77 тн буюу 10.1 сая төгрөгийн цемент он дамнан хадгалагдан зарцуулалт хийгдээгүй үлдэгдлээр тайлагнагдаж байна. Энэ нь эхэлж авснаа эхэлж зарлага болгох аргыг ашиглаагүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Эрсдэл:

Материалын чанар муудах, хугацаа дуусах зэрэг үргүй зардал гарах.

3.3. Өгсөн зөвлөмж

Материалыг эхэлж авснаа эхэлж зарлагадах аргыг ашиглаж байх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид хэрэгжүүлж ажиллана.

4. **Балансын данстай холбоотой асуудал**

4.1. Илрүүлэлт:

Тайлант онд өөрийн хөрөнгөөр шинээр худаг өрөмдөх ажил гүйцэтгүүлэх гэрээгээр гүйцэтгүүлсэн 76.7 сая төгрөгийн 3 худгийг тайлан бүртгэлд орлогд тусгаагүй, тайлант оны зардлаар тайлагнасан нь Сангийн Сайдын 2017 оны 361 дүгээр дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх” зааврын “1.Үндсэн хөрөнгө”-д “Нэгээс дээш тайлант хугацаанд үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, бусдад түрээслүүлэх эсхүл захиргааны зориулалтаар ашиглаж байгаа биет хөрөнгө үндсэн хөрөнгөнд хамаарна” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Эрсдэл:

Хөрөнгө шамшигдах, хадгалалт хамгаалалтгүй болох.

4.3. Өгсөн зөвлөмж

Хөрөнгийг данс бүртгэлд үнэн зөв тусгах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн.

5. **Зардлын данстай холбоотой асуудал**

5.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд худалдан авсан 20.0 сая төгрөгийн бараа материал, ажил үйлчилгээний анхан шатны баримт нь цахим И баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.3.2, 17.6 заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “хэмжилт”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

5.2. Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй байх.

5.3. Өгсөн зөвлөмж

Дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид хэрэгжүүлж ажиллана.

6. Дотоод хяналттай холбоотой асуудал

6.1 Илрүүлэлт:

Шилэн дансны мэдээллийг шалгахад мэдээллээ бүрэн байршуулсан боловч 2020 оны тайлант хугацаанд 31 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.

6.2 Эрсдэл:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэхгүй байх

6.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д заасан *"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"* гэсэн заалтыг хэрэгжүүлж, цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тайлбар ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Дорноговь АЗЗА ТӨХК-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2021-3-15			ДГА-2021/1/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дорноговь АЗЗА ТӨХК		Сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үндсэн хөрөнгийн тавилга эд хогшлын дансанд 6 нэр төрлийн компьютер, принтерийг бүртгэсэн байна.	6.8	Зөвлөмж	Захирал, Нягтлан бодогч	А.Баттогтох, Б.Тунгалагтуяа
2	Бараа материалын дансанд 4.4 сая төгрөгийн хөрөнгийг нэр төрлөөр тайлан бүртгэлд тусгалгүй материал гэж нийт дүнгээр бүртгэсэн байна.	4.4	Зөвлөмж	Захирал, Нягтлан бодогч	А.Баттогтох, Б.Тунгалагтуяа
3	Бараа материалын данс бүртгэлд 30 тн буюу 5.5 сая төгрөгийн цемент он дамнан хадгалагдан зарцуулалт хийгдээгүй үлдэгдлээр тайлагнагдаж байна.	5.5	Зөвлөмж	Захирал, Нягтлан бодогч	А.Баттогтох, Б.Тунгалагтуяа
4	Өөрийн хөрөнгөөр шинээр худаг өрөмдөх ажил гүйцэтгүүлэх гэрээгээр гүйцэтгүүлсэн 3 худгийг тайлан бүртгэлд орлогод тусгаагүй, тайлант оны зардлаар тайлагнасан байна.	-	Зөвлөмж	Захирал, Нягтлан бодогч	А.Баттогтох, Б.Тунгалагтуяа
5	Тайлант хугацаанд худалдан авсан 20.0 сая төгрөгийн бараа материал, ажил үйлчилгээний анхан шатны баримт нь цахим И баримтаар нотлогдохгүй байгаа нь санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй, НӨАТТ хуулийн 17 дугаар зүйлийн 17.3., 17.3.2., 17.6. заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.	-	Зөвлөмж	Захирал, Нягтлан бодогч	А.Баттогтох, Б.Тунгалагтуяа
6	Шилэн дансанд хуулийн дагуу байршуулах 191 мэдээллээс 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Зөвлөмж	Захирал, Нягтлан бодогч	А.Баттогтох, Б.Тунгалагтуяа
ДҮН		16.7			